



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 4/386

Улаанбаатар хот

Коронавируст халдвар (КОВИД-19)-тай иргэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх түр ор дэлгэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдварын тархалтын нөхцөл байдалтай холбогдуулан “Коронавируст халдвар (КОВИД-19)-тай иргэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх орны тоо”-г нэгдүгээр хавсралтаар, “Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төвийн дотор, мэдрэлийн тусламж үйлчилгээг шилжүүлэх хуваарь”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-иI-т 130, Нийслэлийн Баянзүрх дүүргийн Энэрэл эмнэлэгт 440, Баянгол дүүргийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эмнэлэгт 15, ахмадын эмнэлэгт 20, Монголын үндэсний их сургуулийн дотуур байранд 200 ор, Хан-Уул дүүргийн Туул тосгоны эмнэлэгт 80, Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төвд 130, Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэгт эрчимт эмчилгээний 35, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвд 30, Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвд 60, Багануур сувилал 100, Авецина эмнэлэгт 60, Филошип эмнэлэгт 27, Улаанбаатар төмөр замын нэгдсэн эмнэлэгт 40, Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэнд 100, Төв аймгийн Ар жанчивлан сувилалд 75, Хүмүүн цогцолбор сургуулийн дотуур байранд 100, Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд 120, Уулын баяжуулах үйлдвэрийн эмнэлэг сувилалд 100, Ачит эмнэлэгт 50 орыг КОВИД-19-ын халдвартай иргэдэд эрүүл мэндийн тусламж үзүүлэх зорилгоор түр хугацаагаар дэлгэсүгэй.

3. Коронавируст халдварын оношилгоо, эмчилгээ, халдварын сэргийлэлтийн холбогдох журам, зааврын дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх бэлэн байдлыг ханган ажиллахыг Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II (А.Эрдэнэтуяа)-т, Нийслэлийн Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төв (Э.Бодьцэцэг)-д, Баянзүрх дүүргийн Энэрэл эмнэлэг (А.Амартүвшин)-т, Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв (Д.Тамир)-д, Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв (З.Балдандугар)-д, Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв (Ч.Өнөрсайхан)-д, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв (Ц.Лхагва)-д, Авецина эмнэлэг (Д.Эрдэнэчимэг)-т, Филошип эмнэлэг (С.Мөнхтуяа)-т, Багануур дүүргийн эрүүл мэнд (Д.Шинэбаяр)-д, Улаанбаатар төмөр замын нэгдсэн эмнэлэг (С.Еркегул)-т, Төв аймгийн нэгдсэн эмнэлэг (Н.Энхтайван)-т, Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв (Ц.Наран-Эрдэнэ)-д тус тус үүрэг болгосугай.

141211636

4. Тушаалын хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүй, хүний нөөцийн дэмжлэг үзүүлж, ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Буянтогтох), Төрийн захиргааны удирдлагын газар (П.Эрхэмбаяр), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д, Эмнэлзүйн зөвлөх баг, Халдварт өвчин судлалын үндэсний төв (Л.Баттөр)-д тус тус даалгасугай.

5. Коронавируст халдварын голомтын ариутгал, халдварын сэргийлэлтийг хангахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Л.Энхсайхан/-т, Зоонозын өвчин судлалын үндэсний төв /Н.Цогбадрах/-д тус тус даалгасугай.

6. Эмнэлзүйн заавраар эрэмбэлэн ангилалтыг зөв хийж, шатлалын дагуу тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмнэлзүйн байдлаас шалтгаалан эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх зохицуулалтыг хийж ерөнхий зохион байгуулалтаар ханган ажиллахыг Орхон аймгийн эрүүл мэндийн газар (Д.Сүхээ), Төв аймгийн эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа), Нийслэлийн эрүүл мэндийн газар (Б.Бямбадорж)-д үүрэг болгосугай.

7. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хэвтүүлэн эмчлэхтэй холбоотой зардлыг холбогдох тушаал, журмын дагуу хянаж ор дэлгэн ажиллуулсан өдрөөс эхлэн Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Л.Бямбасүрэн)-д даалгасугай.

8. Коронавируст халдварын голомтын ариутгал, халдварын сэргийлэлтийг хангахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Л.Энхсайхан), Зоонозын өвчин судлалын үндэсний төв (Н.Цогбадрах)-т даалгасугай.

9. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Д.Ганцэцэг)-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 06
дүгээр сарын 18 өдрийн 386 дугаар
нэгдүгээр хавсралт


**Коронавируст халдвар (КОВИД-19)-тай иргэнд эмнэлгийн тусламж,
үйлчилгээ үзүүлэх орны тоо**

№	Эрүүл мэндийн байгууллага	Одоо ажиллаж байгаа орны тоо	Нэмж дэлгэсэн		Нийт орны Тоо
			Энгийн орны тоо	Үүнээс эрчимт эмчилгээний	
1.ТӨРӨЛЖСӨН ЭМНЭЛГҮҮД					
1.	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	80	-	-	80
2.	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	40	-	-	40
3.	Улсын гуравдугаар төв эмнэлэг	100	-	-	100
4.	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	103	-	-	103
5.	Арьсны өвчин судлалын үндэсний төв	40	-	-	40
6.	Гэмтэл согог судлалын үндэсний төв	40	-	-	40
7.	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	6	-	-	6
8.	Хавдар судлалын үндэсний төв	13	-	-	13
9.	Халдварт өвчин судлалын үндэсний төв	280	60	-	340
10.	Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II	700	130	-	830
11.	АШУУИС-ийн Монгол-Япон эмнэлэг	152	-	-	152
12.	Цэргийн төв эмнэлэг	382	-	-	382
13.	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	126	-	-	126
14.	Төмөр замын нэгдсэн эмнэлэг	40	40	-	80
15.	Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг	190	-	-	190
16.	Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг	180	-	-	180
17.	Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг	200	-	30	230
18.	Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв	-	130	-	130
19.	Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв	245	35	-	280
20.	Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг	150	-	-	150
21.	Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төв	-	80	-	80

22.	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв		30	2	32
23.	Нийслэлийн Өргөө амаржих газар	10	20	-	30
24.	Нийслэлийн Амгалан амаржих газар	10	20	-	30
25.	Энэрэл эмнэлэг төв байр	-	75	4	75
	Нийт	3087	650	36	3737
2. ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА					
26.	Гэгээн манал эмнэлэг	65	-	-	65
27.	Ачтан эмнэлэг	140	-	-	140
28.	Шиномед эмнэлэг	50	-	-	50
29.	Нандин ухаан	50	-	-	50
30.	Ээлтэй оточ	35	-	-	35
31.	Синдура Мед	50	-	-	50
32.	Уламжлалт анагаах ухааны Элэг судлалын клиник төв	100	-	-	100
33.	Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэн	-	100	-	100
34.	Сэргээн засах клиник эмнэлэг	228	-	-	228
35.	Авецина эмнэлэг	-	60	-	60
36.	Филошип эмнэлэг	-	27	-	27
37.	Энэрэл эмнэлэг /Голд медикал/	-	40	-	40
38.	Нийт	718	227	-	945
3. КОВИДЫН ХАЛДВАРТАЙ ХӨНГӨН ӨВЧТӨН ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ СУВИЛАЛ, ДОТУУР БАЙР					
39.	Жаргалант сувилал	83	-	-	83
40.	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн дотуур байр	392	-	-	392
41.	Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төвийн харьяа сувилал	60	-	-	60
42.	Монголын үндэсний их сургуулийн дотуур байр	300	-	-	300
43.	Монголын үндэсний их сургуулийн эмнэлэг	-	200	-	200
44.	Багануур сувилал	-	100	-	100
45.	Энэрэл эмнэлэг /Өргөө-2/	-	250	-	250
46.	Энэрэл эмнэлэг /Улаанбаатар ИС-ын дотуур байр/	-	75	-	75
47.	Нийт	835	625	-	1460

4. АЛСЛАГДСАН 3 ДҮҮРГИЙН ЭМНЭЛЭГ				
48.	Багануур дүүргийн эрүүл мэндийн төв	70	-	70
49.	Налайх дүүргийн эрүүл мэндийн төв	50	-	50
50.	Багахангай дүүргийн эрүүл мэндийн төв	17	-	17
Нийт		137		137
5. ОРОН НУТАГТ ДЭЛГЭЖ БАЙГАА ОРНЫ ТОО				
51.	Орхон аймгийн Ачит эмнэлэг	-	50	50
52.	Орхон аймгийн Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын Эрдэнэт сувилал	-	100	100
53.	Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээ төв	-	120	120
54.	Төв аймгийн Хүмүүн цогцолбор сургуулийн дотуур байр	-	100	100
55.	Төв аймгийн Ар жанчивлан сувилал	-	75	75
Нийт		-	445	445
Бүгд		4777	1947	6724

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 06
дүгээр сарын 18 өдрийн 1/36 тушаалын
хоёрдугаар хавсралт



Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төвийн дотор, мэдрэлийн тусламж, үйлчилгээг шилжүүлэх хуваарь

№	Байгууллагын нэр	Тусламж, үйлчилгээний чиглэл	Хороодын хувиарлалт	Орны тоо				Эхлэх хугацаа
				Дотор	Мэдрэл	Эрчимт эмчилгээ	Нийт ор	
1	Асралт мед эмнэлэг	Дотор, мэдрэл	1,2,3,4,5,22,33,34,35,26,31,36,43	28	-	7	35	2021.06.20
2	Номуун эмнэлэг	Дотор, мэдрэл	7,8,9,10,11,12,13,14,15,24,25,28,40,41,42	28	8	4	40	2021.06.19
3	ЦНС эмнэлэг	Дотор, мэдрэл	6,16,17,18,19,20,21,23,27,29,30,32,37,38,39	-	30	-	30	2021.06.21
Нийт				56	38	11	105	